

Уулбаян сумын Засаг Даргын Тамгын Газрын
2023 оны 03 дугаар сарын үйл ажиллагааны тайлан
2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр

Суманд зохион байгуулагдсан үйл ажиллагаа:

2023 оны 03 сарын 24-ны өдөр Сумын Иргэдтэй уулзан мэдээллийн цаг хийж иргэдийн санал хүсэлтийг сонсож ажиллалаа. Уг мэдээллийн хуралд нийт 60 гаруй иргэд оролцсон. Албан байгууллагын дарга нар цаг үеийн мэдээ мэдээллийг хүргэлээ.



Сумын ойр орчим болон хөдөөгүүр үхсэн малын сэг зэмийг цэвэрлэх ажлыг зохион байгууллаа.



Сургуулийн өмнөх байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр:

- “Уран жиргээ-2023” уралдааныг сумын Соёлын төвтэй хамтран зохион байгуулж 5 бүлгийн 41 хүүхэд оролцож, 1 хүүхэд цэцэрлэгээ төлөөлөн аймгийн уралдаанд амжилттай оролцсон.
- 3 сарыг ажил эрчимжүүлэх сар болгон зарлаж 23 ажлыг төлөвлөн ажиллаж байна.
- Аймгийн “Оюун ухаан”-ы 5-р наадамд 2 хүүхэд нэг багш оролцож, туслах багш А.Шүрэнчулуун амжилттай оролцож Дэд байр эзэллээ.

Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлээр:

Сумын нийт хүүхэд багачууд, эцэг эх асран хамгаалагчид, иргэд хөдөлмөрчид, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийг "Судар эгшиглэн -2023" төсөлд илүү олноороо оролцохыг уриалж ЕБС-иас өдөрлөг зохион байгууллаа. Өдөрлөгт нийт 1-9 дүгээр ангийн 18 бүлгийн 454 суралцагч, сумын ИТХ, ЕБС, ЭМТ, Цэцэрлэг, ЗДТГ, Соёлын төвын хамт олны төлөөлөл оролцлоо.

- Итали улсын хөрөнгө оруулалттай ASIA MONGOLIA ТББ-аас хэрэгжүүлж буй "Орон нутгаас Дэлхий рүү" төслийн хүрээнд " МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ- ИТ код бичих" өдөрлөг амжилттай зохион байгуулагдлаа. Үүнд: 1. ИТ клубын 20 сурагчид өөрсдийн сурч мэдсэнээ түгээж бусад 6-9 р ангийн 80 сурагчдад хичээл заав.
- ASIA MONGOLIA ТББ-аас номын сангийн тохижилт болон ухаалаг самбар худалдан авахад 16391770 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэв.
- Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын харъяа Хөдөлмөрийн Гавъяаны Улаан Тугийн одон, алтан гадас одон, спортын мастер Батсүхийн Загдрагчаагийн нэрэмжит ААШ өсвөр үеийн жудо бөхийн тэмцээнд 10 гаруй багийн 330 гаруй тамирчдаас:

38кг жинд: 7а ангийн сурагч Эрдэнэчулууны Намсрайжав - АЛТАН медаль
42 кг жинд : 8а ангийн сурагч Хүрэлбаатарын Оргилбаатар - АЛТАН медаль
+73 кг жинд : 8б ангийн сурагч Эрдэнэсүхийн Үлэмжбаясах -АЛТАН медаль
+73 кг жинд: 8б ангийн сурагч Нямдаваагийн Өсөхбаяр -ХҮРЭЛ медаль хүртэж, сайхан амжилт үзүүллээ. Дасгалжуулагч багш Э.Мөнхбаатар.

- Улсын төрөлжсөн олимпиадын 2-ын даваанд оролцсоноос нийт 9 багш, 12 сурагчдаас 9б ангийн суралцагч Э.Буянбадрах -Газарзүй хичээлийн төрөлд алтан медаль - Бэлтгэсэн багш Ц.Алтантүлхүүр, Т.Вера,
- 9а ангийн суралцагч Э.Баярдулам -Химийн хичээлийн төрөлд алтан медаль- Бэлтгэсэн багш Ж.Нэргүй
- Хими- биоллгийн багш Ж.Нэргүй -Химийн багшийн төрөлд мөнгөн медаль хүртлээ.
- Мөн 9б ангийн сурадлцагч Н.Биндэр - Физикийн хичээлийн төрөлд 4-р байр - Бэлтгэсэн багш О.Сарангэрэл,
- 9б ангийн суралдцагч А.Мөнгөнсор -Мэдээллийн технологийн хичээлийн төрөлд 4-р байр -Бэлтгэсэн багш Б.Оюунжаргал
- 9а ангийн суралцагч Б.Мөнх-Ертөнц - Түүхийн хичээлийн төрөлд 5-р байр Бэлтгэсэн багш Ц.Алтантүлхүүр,
- багш Д.Мөнх-Эрдэнэ - Дизайн технологийн багшийн төрөлд 5-р байрт шалгарлаа.

Соёлын байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр:

- Монгол Улсынхаа төлөө халуун амь бүлээн цусаа урсгаж явсан Монгол Улсын баатарлаг эрчүүдийг эргэн дурссан залуу үедээ танин мэдүүлэх зорилогтой “Эх орончдын” баярыг 03 сарын 01-ийг тэмдэглэн өнгөрүүлдэгтэй холбоотой “АХА” тэмцээн болон үдшийн цэнгүүн зохион байгууллаа. АХА тэмцээнд 43, үдэшлэгт нийт 115 хүн оролцсон.
- Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан 03 дугаар сарын 08-ыг угтан Эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран 3 өдрийн ажил зохион байгуулж ажилласан. Энэ ажлын хүрээнд Уулбаян сумын эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран “Бүсгүйчүүд дуулж байна” тэмцээнийг зохион явууллаа.
- Эр цэргийн баярын өдрийг тохиолдуулан 03 сарын 18-нд Монгол төрийн **“Эрийн гурван наадмын”** нэг болох залуу бөхчүүдийн барилдааныг зохион явууллаа. Барилдаанд 16 залуу бөх оролцов. Цэргийн баярын хөтөлбөрт үдшийн цэнгүүн зохион байгуулж 95 хүн хамрагдлаа.
- ТӨРИЙН СОЁРХОЛТ, УРЛАГИЙН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН НЭРТ ХҮҮХДИЙН ЗОХИОЛЧ ЖАМБЫН ДАШДОНДОГ ӨГСНЫ НЭРЭМЖИЛТ **“Уран жиргээ-2023”** уралдааны I шатыг ЕБС, Хүүхдийн цэцэрлэгтэй хамтран амжилттай зохион байгууллаа. ЕБС-ын бага, дунд бүлгийн 53 сурагч, Хүүхдийн цэцэрлэгийн 5 бүлгийн 41 сурагч уран уншиж, авьяас билгээ сорьлоо.

Нийгмийн даатгалын чиглэлээр:

Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 163801.3 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээ.

Үүнээс:

- Ажил олгогчоос шимтгэлд -142249.1 мян төг
- Сайн дурын даатгалын шимтгэл- 17479.2 мян төг
- ЭМДаатгалын шимтгэл -4073.0 мян төг орлоо.

Тэтгэвэр, тэтгэмжийг тогтоож, олгох ажлыг хуулийн хугацаанд зохион байгуулж НДаатгалын санд мян төгрөгийн шимтгэлийг төвлөрүүлж, тэтгэврийн санд 595000.0 мян төгрөгний санхүүжилт, тэтгэмж дээр 0,0 мян төгрөгний санхүүжилт авснаар

- Тэтгэвэрт - 483 тэтгэвэр авагчдад 710441.9 мян төгрөгний тэтгэвэр,
- ХЧТА тэтгэмжинд- 3 даатгуулагчдад 257.8 мянган төгрөг,
- Оршуулгын тэтгэмжинд- 3 тэтгэвэр авагчдад 6000,0 мян төгрөг,

- Жирэмсэн амаржсаны тэтгэмжийг- 5 даатгуулагчдад 7802.4 мян төг, Нийт724502.1 мян төгрөгний тэтгэвэр, тэтгэмжийг сар бүр олгоод олголтын зөрчилгүй ажиллаж байна.

Хөдөлмөр халамж үйлчилгээний чиглэлээр:

- Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 1 удаа хийж, асаргаа сунгуулах 2 иргэний асаргааг сунгасан.
- 3 дүгээр сарын хүүхдийн мөнгөний асуудлаар холбогдсон 21 иргэнд мэдээл өгч ажилласан. Үүнээс хүүхдийн мөнгө нь орохгүй 6 иргэн гарсан.
- Шинээр төрсөн 3 хүүхдийн өргөдлийг хүлээн авч программд бүртгүүлсэн.
- Доорх заруудыг Уулбаян сум /Зар/, зарын группүүдээр байршуулсан.

- Төсөл хөтөлбөр

-Хүүхдийн мөнгөний бүртгэл, шалгах

-E-mongolia- н зааварыг

ЕХаламж цахим системд САМ-н шалгуур хангаагүй одонгийн мөнгө ороогүй 7 иргэний мэдээллийг шинэчилж шинээр бүртгэсэн.

Цалинтай аав хөтөлбөрт 1иргэн, цалинтай ээж-2 иргэн, Жирэмсэн эхийн тэтгэмжинд 7 иргэн бүртгэсэн.

Мал эмнэлэгийн чиглэлээр:

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны 03 сарын 03 ны өдрийн 02 албан даалгавар, аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2021 оны 03 сарын 09 ний өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 1/38 албан тоот, сумын Засаг даргын 2021 оны 03 сарын 09 өдрийн А/27 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2021-03-02 өдөр Жавхлант багийн Засаг дарга О.Дамдинсүрэнтэй хамт 4, 5-р багийн нутагт отроор ирсэн Өвөрхангай аймгийн Гучин ус сумын 5 өрх, Халзан сумын 2 өрх өөрийн сумын 10 гаруй хот айлаар орж мал эмнэлгийн ажил үйлчилгээнд хамрагдсан байдал, өвөлжөө хаваржааны ойр орчноо цэвэрлэх, хүүр сэг зэм устгах талаар үүрэг чиглэл өгч ажилласан. Мөн энэ Улаанбаатар хотын төв замын хажууд үхсэн 8 адуу, 25 үхэрийн сэг зэм хаясныг олж тогтоон сумын устгалын цэгийн нүхэнд булж устгахаар болсон.

Төсөв, төрийн сангийн чиглэлээр:

Сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 04 тоот тогтоолоор батлагдсан 2023 оны төсвийг мөрдөн ажиллаж байна. 3 сарын байдлаар орон нутгийн орлого төлөвлөгөөгөөр 49611,3 мянган төгрөг орохоос 32774,6 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй орлогын төлөвлөгөө 66,0 хувийн биелэлттэй байна.

Орон нутгийн татварын орлогын гүйцэтгэл:

Орлогын нэр төрөл	2023 оны жилийн төсөв	төлөвлөгөө гүйцэтгэл	хувь
НИЙТ ОРЛОГО	388148,0	49611.3	32774.6
ТАТВАРЫН ОРЛОГО	348148,0	47945.3	31624.6
Цалин хөлс түүнтэй ажилтгах орлогын цалингаас суутгасан орлогын албан татвар	123000,0	20500	21566.3
Суутгагчийн хувь хүнд олгосон суутгасан албан татвар	14188,0	2364	
Хадгаламжийн хүүгийн орлого	16000,0	2667.3	3832.1
Үйл ажиллагааны орлогын албан татвар	2000,0	332	350
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	45000,0	7500	110.4
Малын тоо толгойн албан татвар	80000,0	12000.0	5314.9
Бууны албан татвар	960,0		90.0
Улсын тэмдэгтийн хураамж	2000,0	332	360.9
Хог хаягдлын хураамж	9000,0	2250	
Газрын төлбөр	25000,0		
Ан амьтан барих зөвшөөрлийн хураамж	31000,0		
Татварын бус орлого	40000,0	1666.0	1150
Хүү торгуулийн орлого	10000,0	1666.0	1150
Нэр заагдаагүй бусад орлого	30000,0		

Төсөв санхүүгийн талаар:

3-р сарын байдлаар аймгийн санхүүгийн дэмжлэг 139980.0 мянган төгрөг ирээд байна. Төсөвт байгууллагуудад энэ сард өр авлага үүсээгүй байна. Нягтлан бодогч нар хуулийн хугацаанд нь тайлангаа гаргаж аудитын байгууллагаар шалгуулж зөрчилгүй санал дүгнэлт аваад байна.

Аймгийн өмчийн газарт төрийн өмчийн болон орон нутгийн өмчид хуулийн этгээдийн судалгаа, Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлангийн нэгтгэлийг хийж хүргүүлээ.

.Худалдан авах ажиллагааны талаар

ОНХС-аар хийгдэх 2024 оны санал асуулгыг хөрөнгө оруулалт төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг хуралдаж сумын засаг даргын мөрийн хөтөлбөр болон эдийн засаг нийгмийн хөгжлийн бодлогын хэтийн зорилготой уялдуулж бодлого чиглэлийг тодорхойллоо. ОНХС-ийн санал асуулгийг Багийн иргэд нийтийн хурлаар цаасаар болон гар утасны апплекшин ашиглан цахимаар иргэдээс санал асуулгийн авлаа. Одоогоор нийт өрхийн хүн амын 10 гаруй хувийг хамруулаад байна.